

ХЯТАДЫН БАРУУН БҮС НУТГИЙН ХӨГЖИЛ ХИЙГЭЭД ХӨРШ ОРНУУДЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА

*Сэцэнгоо**

Хятадын баруун бүс нутгийн хөгжил зүүн бүсийн далайн эрэг хавийн муж хотуудаас хоцрогдсоны гол шалтгаан нь баруун бүс нутгийн эдийн засгийн өөрчлөн байгуулалт зүүн бүсийн далайн эрэг хавийн нутгийг бодвол төдийлөн сайн гүнзгийрч чадаагүй агаад хил залгаа улс орнуудтайгаа гадаад харилцаа хамтын ажиллагаа харьцангуй доогуур байдаг. Баруун бүс нутгийн Или, Дэхүн, Хөлөнбуйр зэрэг хилийн хотуудын эдийн засаг ХХ зууны 80-аад оноос хойш түргэн өсч буй нь хөрш орнуудтай хилийн худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлсэнтэй шууд холбоотой. Үүнээс үзэхэд, Хятадын баруун бүс нутаг хийгээд хөрш орнуудтай эдийн засгийн талаар хамтран ажиллах нь баруун бүс нутгийн хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэнэ.

Хятадын баруун бүс нутгийн хоцрогдсон байдлыг өөрчлөх зорилгоор ХКН зүүн бүсийн далайн эрэг хавийн нутгийг тогтвортой хөгжүүлэхийн зэрэгцээ, баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийн бодлого боловсруулсан. 1999 оны 9-р сарын 22-нд хуралдсан ХКН-ын XV их хурлаас баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх стратегийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухай тогтоолыг албан ёсоор батлав. 2000 онд Хятадын засгийн газраас баруун бүсийн нутгийг хөгжүүлэх багц төлөвлөгөөг боловсруулан баталснаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын анхаарлыг татаж, Хятадын баруун бүсийн нутаг хил залгаа улс орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаа өргөжүүлэн хөгжүүлэх нөхцөл боломжийг олгосон юм.

Зах зээлийн нөхцөл боломжийн талаар Хятадын баруун бүсийн нутаг томоохон зах зээл эзлэхээс гадна баруун урд хил дагуух Зүүн өмнөд Азийн орнууд, баруун хойт хил дагуух Төв Азийн орнууд болон хойт хөрш Орос зэрэг томоохон зах зээлтэй орнуудтай газар зүйн хувьд ойр дөт байдаг.

Зүүн өмнөд Азийн Вьетнам, Лаос, Бирм зэрэг орны эдийн засгийн газар зүйн онцлогоос үзэхэд, өмнөд хэсгээрээ харьцангуй хөгжилтэй, Хятад улстай хиллэж байгаа хойт хэсэг нь хоцрогдсон байх бөгөөд Хятадын эдийн засгийн хөгжилтэй харьцуулахад харьцангуй ялгаатай юм. Хятадын баруун хойгуур хиллэдэг Төв Азийн орнууд болон ОХУ-ын байдлаас үзэхэд, эдийн засгийн бүтэц нь түүхий эд, ашигт малтмал олборлох үйлдвэрлэлд тулгуурласан бөгөөд өргөн хэрэглээний бараа үйлдвэрлэлийн хүчин чадал харьцангуй доогуур байна. Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл /ЭЗХТЗ/ задарснаар өргөн хэрэглээний бараа нийлүүлэлт буурах

*Сэцэнгоо - Өвөр Монголын Их сургуулийн Хөрш улс судлалын хүрээлэнгийн лектор, докторант

хандлага ажиглагдаж байна. Хятадаас дээр дурьдан буй орнуудад экспортолж байгаа хямд бараа энэхүү хоосон орон зайг бөглөж байна. Олон улсын эдийн засгийн хөгжлийн энэхүү зөрүү нь Хятадын баруун бүсийн нутаг болон хөрш орнуудын хооронд эдийн засгийн хамтын ажиллагаа өрнүүлэх шаардлага их байгааг харуулж байна.

БНХАУ нь 2002 онд зүүн өмнөд Азийн улсуудын холбоотой “Өмнөд тэнгисийн орнууд хоорондын хамтын ажиллагааны тунхаглал”-д гарын үсэг зурж, 2003 онд “Зүүн өмнөд Азийн харилцаа, хамтын ажиллагааны гэрээ”-нд нэгдэн оржээ. Энэ нь БНХАУ болон зүүн өмнөд Азийн улсуудын холбооны эдийн засгийн хамтын ажиллагаа улс төрийн талаар шинэ баталгаатай болсныг харуулж байна. 2004 оны 11-р сард, Лаос улсын нийслэл Вьентянд болсон Зүүн өмнөд Азийн 10 улс болон Япон, БНСУ, БНХАУ гурван улсын төрийн тэргүүн нар оролцсон хуралд, Хятад болон ЗӨАОХ-ны орнуудтай олон талын хамтын ажиллагааны хэлэлцээ хийжээ.

Баруун бүсийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлж эхэлснээс хойш Хятад улс болон ЗӨАОХ-ны орнуудтай уул уурхай, хөдөө аж ахуй, ус ашиглалт зэрэг цөөн хэдэн салбарт хамтран ажиллаж байсан бол одоо улам өргөжиж ажиллах хүчний нөөц, банк санхүү, аялал жуулчлал, зам тээвэр, холбоо, эрчим хүч, байгаль орчны хамгаалал, соёл гэгээрэл зэрэг олон салбарт үйл ажиллагаа явуулах болжээ. 1993 онд хоёр талын худалдааны нийт эргэлт 10.68 тэрбум ам.долларт хүрч, 10 дахин өссөн байна. 1990 оноос хойш, ЗӨАОХ нь Хятадын гадаад худалдааны тав дахь том түнш буюу хоёр талын худалдааны нийт эргэлт жил дараалан 20 хувиар нэмэгдсээр байна.

Одоогоор Хятад орон болон ЗӨАОХ-ны хооронд “БНХАУ ба ЗӨАОХ-ны орнуудын чөлөөт худалдааны бүс”, “Пан Азийн төмөр зам”-ын бүтээн байгуулалт, Азийн авто замын сүлжээ зэрэг төслийг хамтран хэрэгжүүлж байна. Эдгээр хамтын ажиллагаа нь Хятадын баруун бүсийн хөгжилд ховорхон тохиолдох ашигтай боломжийг ханган өгч байгаа юм. Юньнань мужаар жишээлэхэд, Юньнань муж ЗӨАОХ-ны хэд хэдэн улстай 4060 км газраар хиллэдэг бөгөөд хил дагуу улсын зэрэглэлийн 20 боомтоор 10 улстай харилцдаг. Одоо уг мужийн гадаадын хөрөнгө оруулалт нийт 447 сая ам.долларт хүрэв. Нармай Азийн төмөр зам нь Куньмингээс Сингапур хүрэх юм. Энэхүү төмөр замын бүтээн байгуулалтын дагуу Куньмин-Банкокийн хооронд авто зам тавигдах бөгөөд Куньминд олон улсын нисэх онгоцны буудал шинээр байгуулахаар төлөвлөж байгаа ажээ. Эдгээр төслүүд хэрэгжвэл Юньнань мужийн эдийн засгийн хөгжил эрчимжиж, уг муж болон ЗӨАОХ-ны орнууд хоорондын хэлхээ холбоо улам зузаарах болно. “БНХАУ-ЗӨАОХ-ны орнуудын чөлөөт худалдааны бүс” байгуулагдвал ЗӨАОХ-ны ДНБ-ий өсөлт нь 0.3 хувьд хүрэх болно. Энэ чөлөөт бүс 1700 сая хэрэглэгчид, 1408

мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэр, 2000 тэрбум ам.долларын ДНБ, 1300 тэрбум ам.долларын худалдааны эргэлттэй эдийн засгийн бүс нутаг болох юм. Ийм асар том зах зээл нь эдийн засгийн хөгжлөөр хоцрогдсон Юньнань мужид хөгжлийн ашигтай боломж олгож байна.

НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа Түмэн голын бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд зүүн хойт Хятад, Монгол Улс, ОХУ-ын алс дорнодын бүс нутаг, Япон, БНСУ зэрэг 5 улс энэ бүс нутагт харьяалагдаж байна. Хятадын баруун бүсийн хөгжлийн стратегийн хүрээнд хамрагдах ӨМӨЗО нь хамтын ажиллагааны энэхүү бүрэлдэхүүнд мөн багтаж байгаа учраас цаашид хөгжих асар их боломж тохиож байна.

БНХАУ-ын баруун хойт бүсэд орших Шиньжаан, Ганьсу, Өвөр Монголын баруун хэсэг болон төв Азийн орнууд, ОХУ, Монгол Улсын баруун зүгийн нутагтай эдийн засгийн хамтын ажиллагаа өрнүүлж байна. Эдүгээ Шиньжааны хойт хэсгийн төмөр замын бүтээн байгуулалт, Шиньжаанаас Туркийн баруун хэсэг хүртэлх төмөр замыг холбох зэрэг төсөл дээр хамтран ажиллаж байна. Шиньжаан, Өвөр Монголд хэд хэдэн томоохон боомтыг нээж, Төв Азийн орнуудтай худалдаа хийж байна. Өвөр Монголоор жишээлэхэд Эрээн, Хөххот /агаарын/, Ганцмод, Зүүнхатавч, Архашаат зэрэг улсын зэрэглэлийн 5 боомт ба Цэг, Мандал, Рашаан, Өвдөг зэрэг мужийн зэрэглэлийн 4 боомтоор, Монгол Улстай хилийн худалдаа хийж байна. 2003 онд Өвөр Монгол болон Монгол Улс хоорондын хийсэн худалдаа 220 сая ам.доллар буюу 6.5 хувиар өссөн байна. Одоогоор БНХАУ Монгол Улстай “Замын-Үүдийн чөлөөт худалдааны бүс”-ийг бүтээн байгуулах том төслийг хамтран хэрэгжүүлж байна. Энэ нь Өвөр Монголын эдийн засгийн хөгжилд ашигтай нөхцөл боломжийг бүрдүүлэх болно.

Төв Азийн орнууд газрын тосоор баялаг болохоор Хятад орноос Төв Азийн орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагаа өрнүүлбэл Хятадын эдийн засгийн хөгжилд чухал нөлөө үзүүлэх юм. Эдийн засгийн эрчимтэй хөгжлийн шаардлагаар, Хятадын газрын тосны импортын хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. 2004 онд Хятадын нефтийн импорт 110 сая тоннд хүрсэн нь өнгөрсөн оныхоос 21 хувиар өсчээ. Холбогдол бүхий байгууллагын төлөвлөж буйгаар 2015 он гэхэд Хятадын хэрэгцээний нефтийн хэмжээ Азийн бүх орнуудын хэрэгцээний нийт хэмжээний 50 хувийг эзэлнэ. 2010 он гэхэд, Хятад улс жил бүр 300 сая тонн нефть хэрэглэх болно. Харин өөртөө үйлдвэрлэх чадвар нь жилд зөвхөн 165 сая тонн хүрнэ. Иймээс хүрэлцэхгүй хэсгийг импортлох шаардлагатай болно. Хятадын баруун хойт талаар хөршилдөг орнууд бол Хятад улсад нефть хангах гол орнууд болно.

2004 онд Хятадын засгийн газраас байгалийн хийд хайгуул хийх, дэд бүтэц, байгалийн хийн цахилгаан станц, том, дунд хотуудын хийн

хангамж зэрэг төслүүдийг хэрэгжүүлэхэд гадаадын ажил хэрэгч хүмүүс /бизнесмен/-ийг идэвхтэй оролцохыг дэмжиж, байгалийн хийн аж үйлдвэрийн салбарыг бүхий л талаар нээлттэй болгосон байна. Энэ нь байгалийн хийн эх баялаг төвлөрч байгаа Хятадын баруун бүс нутаг болон хөрш орнуудын хооронд хамтын ажиллагаа өрнүүлэхэд бас ашигтай нөхцөл боломжийг олгож байгаа юм.

Хятад улс баруун бүс нутгийн хөгжлийн стратегийг хэрэгжүүлээд Хятад дахь гадаадын хөрөнгө оруулалтын байдлыг “Япон-Азийн дөрвөн бар-ЗӨАОХ-БНХАУ-ын далайн эрэг хавийн нутаг” байснаа “далайн эрэг дагуух нутаг - дунд бүс нутаг - баруун бүс нутаг” гэх болж, баруун бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хөрөнгийн баталгаа олгосон байна. Хятадын баруун бүс нутаг болон хөрш орнууд хоорондын хамтын ажиллагаа нь ийнүү хөрөнгө оруулалтаар улам өргөжиж байна. Баруун өмнөд Хятадын Юньнань муж Бирм улсад хөрөнгө оруулалт хийж чихрийн үйлдвэр байгуулж байна, Өвөр Монгол, Ганьсу, Шиньжаан зэрэг муж, ӨЗО хүнсний бүтээгдэхүүн, хөнгөн аж үйлдвэр, барилгын материалын үйлдвэр, хөдөө аж ахуй эрхэлдэг аж ахуйн нэгжүүд төв Азийн орнуудад хөрөнгө оруулалт хийж үйлдвэр эрхэлж байна. Монгол Улсаар жишээлэхэд 2000 оны 7-р сар гэхэд Хятадаас Монгол Улсад 71.5 сая ам.долларын хөрөнгө оруулж, Монгол Улс дахь гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээний 23.4 хувийг эзэлж, Монгол Улсад оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээгээр Хятад улс эхний байрыг эзэлжээ.

Хятад улс баруун бүс нутгийг хөгжүүлэх стратегийг гүнзгийрүүлэн хэрэгжүүлэхийн дагуу баруун бүс нутаг болон хөрш орнуудын хамтын ажиллагаа улам эрчимтэй хөгжих бөгөөд хамтын ажиллагааны хөгжлийн дагуу Хятадын баруун бүс нутгийн эдийн засгийн хөгжил ч түргэсэх болно.

Ашигласан эх сурвалж

1. Lu Jian Ren. “Visualize Relationship Between China and East Alliance through Chinese whole – heated Tsungmi Vivtims Rescue Efforts”. “West forum” 2005.28, p25-28
2. Удо Б.Баркманн. “1990-2003 он хүртэлх Монгол, Хятадын эдийн засгийн харилцааны тухай”. “Олон улс судлал” УБ, 2003. №4, х.52-57
3. А.Буянтөгс. “Монголын уул уурхайн салбар ба гадаадын шууд хөрөнгө оруулалт”. “Олон улс судлал” 2003. №4, х.37-41
4. Н.Отгонсүрэн. “Хятад ба АСЕАН-ы орнуудын чөлөөт худалдааны бүсийн тухайд”. “Олон улс судлал”. УБ, 2004. №1 х.87-91
5. Н.Улаан-Од. “Өвөр Монгол болон Монгол Улсын хоорондын эдийн засгийн хамтын ажиллааны тухай өгүүлэх нь”. “Өвөр Монголын нийгмийн шинжлэх ухаан” сэтгүүл, 2005.1. х.20-23 Хөххот.
6. “Солонго” сэтгүүл 2003.11 х.2, 2004.8 х.4, 2004.10. х3, Хөххот.